



**Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт,
засвар үйлчилгээний өнөөгийн байдлын
үнэлгээ болон бүртгэл, мэдээний сангийн
програм хангамж танилцуулах
уулзалт, семинар**

Улаанбаатар хот

2018 он

1. ТАНИЛЦУУЛГА

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба болон Эрүүл мэндийн яамны Эм, үйлдвэрлэл технологийн газартай хамтран Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотод 2018 оны 06 дугаар сарын 14-15-ны хооронд Эрүүл мэндийн яамны сургалтын Б зааланд 2 хоногийн уулзалт, семинарыг зохион байгуулан явуулсан.

Уулзалт, семинарыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын инженер техникийн ажилчдад зориулан явуулсан болно. Уулзалт, семинар нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний өнөөгийн байдлын үнэлгээ болон бүртгэл, мэдээний сангийн програм хангамж танилцуулах гэсэн үндсэн хоёр чиглэлээр явагдсан.

2. УУЛЗАЛТ, СЕМИНАРЫН БЭЛТГЭЛ АЖИЛ

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албанаас уулзалт, семинарын удирдамж, хөтөлбөрийг боловсруулж Ерөнхий захирлаар 2018.05.23-ны өдөр батлуулсан. Хөтөлбөрийг боловсруулахдаа эх, хүүхдийн чиглэлийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний өнөөгийн байдлын үнэлгээний тайлангаас гарсан санал зөвлөмж болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөлтийн системийн програм хангамжийн дадлага ажлын материалыг бэлтгэсэн.

Бэлтгэл ажлын хүрээнд уулзалт, семинарын байр захиалах, холбогдох техник, хэрэгслийг бэлдүүлэх, гэрчилгээ, баннер хэвлүүлэх, уулзалт, семинарын материал олшруулах, уулзалт, семинарын бал, дэвтэрээр хангах, өдрийн хоолны захиалга өгөх гэх мэт ажлуудыг урьдчилан хийж бэлтгэсэн.

Уулзалт, семинарт оролцох тухай албан тоотыг бэлтгэж Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 648 дугаар албан бичгээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Үүний хүрээнд уулзалт, семинарт оролцох оролцогчдын нэрс болон бусад холбогдох мэдээллийг урьдчилж авсан болно.

Уулзалт, семинар хийх танхим, прожектор, бусад холбогдох техник хэрэгслийг урьдчилж бэлдэж, зарим мэргэжилтнүүд лекц хэлэлцүүлэн, чиглүүлэгч хийж, ерөнхий зохион байгуулагчаар ажилласан.

3. УУЛЗАЛТ, СЕМИНАРЫН ЗОРИЛГО

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний өнөөгийн байдал болон цаашид авах арга хэмжээг тодорхойлж, холбогдох засвар үйлчилгээний сургалт зохион байгуулж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл нэршил, мэдээний сангийн програм хангамжийг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх;

4. УУЛЗАЛТ, СЕМИНАРЫН ЗОРИЛТ

- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний өнөөгийн байдлын үнэлгээний тайлан танилцуулах;
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, мэдээний сангийн програм хангамжийг танилцуулах, нээлт хийх, турших;
- Эх, нярайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний чиглэлээр сургалт хийх;

5. УУЛЗАЛТ, СЕМИНАРЫН ТОЙМ

2018 оны 06 дугаар сарын 14-ны өдрөөс 15-ны өдрүүдэд зохион байгуулсан уулзалт, семинарт төв эмнэлэг тусгай мэргэжлийн төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төв, дүүргийн нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага зэрэг нийт 75 эрүүл мэндийн байгууллагын 101 эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникчид, болон бусад ажилчид оролцсон.

6. УУЛЗАЛТ, СЕМИНАРТ ЗААСАН СЭДВИЙН ТОЙМ:

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ИЛТГЭЛ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Сэдэв 1: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт засвар үйлчилгээний өнөөгийн байдлын үнэлгээний илтгэл, хэлэлцүүлэг

Сэдэв 2: МХЕГ-ын хяналт шалгалтаар илэрсэн түгээмэл зөрчил дутагдал, түүнийг арилгах арга зам

Сэдэв 3: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний журмын төсөл /хэлэлцүүлэг/

Сэдэв 4: Ёс зүй ба мэдрэмж

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТ

Сэдэв 5: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн техник үзүүлэлт боловсруулах аргачлал

Сэдэв 6: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний урсгал зардлыг тооцох аргачлал

Сэдэв 7: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгах хуудас /check list/, түүнийг хэрэглэх нь

Сэдэв 8: Нярайн амьсгалын аппарат, түүний засвар үйлчилгээ

Сэдэв 9: Нярайн инкубатор, ургийн монитор, түүний засвар үйлчилгээ

Сэдэв 10: Хэт авиан оношилгооны аппарат, түүний засвар үйлчилгээ

Сэдэв 11: Засвар үйлчилгээний чиглэлээр цаашид авах арга хэмжээ

ГУРАВДУГААР ХЭСЭГ. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЭЛ

Сэдэв 12: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөгжил ба бүртгэх асуудалд

Сэдэв 13: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан програм хангамжийн ерөнхий танилцуулга

Сэдэв 14: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журмын танилцуулга

Сэдэв 15: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ерөнхий нэршлийн танилцуулга

Сэдэв 16: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан програм хангамжийн ашиглалт

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ДАДЛАГА СУРГАЛТ

Сэдэв 17: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг ашиглах, мэдээлэл оруулж турших


Сэдэв 18: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг ашиглан тайлан гаргах

7. УУЛЗАЛТ, СЕМИНАРТ ОРОЛЦОГЧИД

2018 оны 06 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулсан уулзалт, семинарт удирдах 4 байгууллагын 8 ажилтан, эрүүл мэндийн яамны харьяа 16 байгууллагын 30 ажилтан, 19 аймгийн эрүүл мэндийн байгууллагын 24 ажилтан, нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 19 байгууллагын 21 ажилтан, хувийн

хэвшлийн 12 байгууллагын 18 ажилтан нийт 75 байгууллагын 101 инженер техникчид болон бусад ажилчид уулзалт, семинарт оролцсон.

8. УУЛЗАЛТ, СЕМИНАРТ ОРОЛЦОГЧДООС АВСАН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА



Сургалтад оролцогсад нь боловсруулсан асуумжийн дагуу санал өгсөнөөс гадна өөрсдийн санал, хүсэлтийг бичиж ирүүлсэн байна. Үүнд:

- Дараагийн сургалтан дээр шинэ дэвшилтэт тоног төхөөрөмжийг танилцуулах;
- Анхан шатан дээр ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд боломжоороо сургалт хийх;
- Сургалтын давтамжийг ойртуулах;
- Сургалтад инженер техникчдийг улсын болон хувийн эрүүл мэндийн байгууллага гэж ялгахгүй бүгдийг хамруулах;
- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулах

9. ДҮГНЭЛТ

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний өнөөгийн байдлын үнэлгээ болон бүртгэл, мэдээний сангийн програм хангамж танилцуулах уулзалт, семинарыг хоёр үндсэн чиглэлийн хүрээнд 2018 оны 06 сарын 14-нөөс 15-ны өдрүүдэд 75 байгууллагын 101 эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч болон бусад ажилчдыг хамруулан зохион байгууллаа.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний өнөөгийн байдлын үнэлгээ хэлэлцүүлэх эхний сэдвийн хүрээнд 2017 онд хийгдсэн үнэлгээний тайланг танилцуулж, зарим нэг эх, нярайн оношилгоо, эмчилгээнд тусламж үйлчилгээ үзүүлж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний талаар хичээл зааж, засвар үйлчилгээний журмын хэлэлцүүлэг хийсэн.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, мэдээний сангийн програм хангамж танилцуулах хоёрдугаар сэдвийн хүрээнд уг мэдээний санг бүрдүүлэх, ашиглах журмын танилцуулга хийж, програм хангамжийн талаар танилцуулга хийж, багаар ажиллуулан өгөгдөл оруулж туршин оруулсан өгөгдлөөс тайлан мэдээ гаргуулж дадлага ажил хийлгэн онол болон практикын мэдлэгийг олгосон.

Хавсралт 1. Уулзалт, семинарын хөтөлбөр

2018 оны 06-р сарын 14, Пүрэв гариг


Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах хүн
09 ⁰⁰ -09 ²⁵	Бүртгэл	Зохион байгуулагчид
НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА		
09 ²⁵ -09 ³⁰	Нээлтийн үг	А.Оюунчимэг, ЭМЯ-ны Эм, үйлдвэрлэл технологийн газрын дарга
09 ³⁰ -09 ³⁵	Нээлтийн үг	А.Илиза, НҮБ-ын Хүн амын сангийн Шадар суурин төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэгч
09 ³⁵ -09 ⁴⁰	Нээлтийн үг	Д.Ганцэцэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирал
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ИЛТГЭЛ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ		
09 ⁴⁰ -11 ³⁰	Чиглүүлэгч: Б.Сансармаа, ЭМХТ-ийн ЭЭТТА-ны ахлах мэргэжилтэн	
09 ⁴⁰ -10 ¹⁰	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт засвар үйлчилгээний өнөөгийн байдлын үнэлгээ	Б.Сансармаа, ЭМХТ-ийн ЭЭТТА-ны ахлах мэргэжилтэн, ТУ-ны магистр, МУ-ын мэргэшсэн инженер
10 ¹⁰ -10 ⁴⁰	МХЕГ-ын хяналт шалгалтаар илэрсэн түгээмэл зөрчил дутагдал, түүнийг арилгах арга зам	Ж.Баярмаа, МХЕГ газар, Эрүүл мэндийн хяналтын Улсын ахлах байцаагч, Доктор
10 ⁴⁰ -11 ¹⁰	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний журмын төсөл /хэлэлцүүлэг/	Р.Энхсүрэн, Б.Санж-Очир, ЭМХТ-ийн ЭЭТТА-ны мэргэжилтэн
11 ¹⁰ -11 ³⁰	Цайны завсарлага	
11 ³⁰ -12 ³⁰	Ёс зүй ба мэдрэмж	Л.Ширнэн, АХБ – “Эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх” төсөл, сургалтын зохицуулагч, Удирдлагын тэргүүлэх магистр
12 ³⁰ -13 ³⁰	Үдийн засварлага	
ХОЁРДУГААР ХЭСЭГ. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТ		
13 ³⁰ -17 ³⁰	Чиглүүлэгч: Ж.Халиунаа, ЭМХТ-ийн ЭЭТТА-ны мэргэжилтэн	
13 ³⁰ -14 ⁰⁰	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн техник үзүүлэлт боловсруулах аргачлал	Н.Гэрэлт-Од, ЭМЯ-ны ЭУТГ-ын ахлах мэргэжилтэн, ТУ-ны магистр, МУ-ын мэргэшсэн инженер
14 ⁰⁰ -14 ³⁰	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний урсгал зардлыг тооцох аргачлал	О.Ялалт, АШУҮИС-ийн Радиологийн тэнхимийн багш
14 ³⁰ -15 ⁰⁰	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгах хуудас /check list/, түүнийг хэрэглэх нь	Р.Даваасүрэн, ЭХЭМҮТ-ийн ЭТТ-ийн тасгийн эрхлэгч, ТУ-ны магистр
15 ⁰⁰ -15 ²⁰	Цайны завсарлага	
15 ²⁰ -15 ⁵⁰	Нярайн амьсгалын аппарат, түүний засвар үйлчилгээ	Ж.Ганбат, УНТЭ-ийн Зөвлөх инженер, МУ-ын мэргэшсэн инженер
15 ⁵⁰ -16 ²⁰	Нярайн инкубатор, ургийн монитор, түүний засвар үйлчилгээ	М.Эрдэнэжаргал, НӨАГ-ын ЭТТ-ийн инженер, ТУ-ны магистр
16 ²⁰ -16 ⁵⁰	Хэт авиан оношилгооны аппарат, түүний засвар үйлчилгээ	С.Содбаяр, Медимпекс интернейшнл ХХК, ЭТТ-ийн ахлах инженер
16 ⁵⁰ -17 ²⁰	Засвар үйлчилгээний чиглэлээр цаашид авах арга хэмжээ	Б.Сансармаа, ЭМХТ-ийн ЭЭТТА-ны ахлах мэргэжилтэн, ТУ-ны магистр МУ-ын мэргэшсэн инженер

2018 оны 06-р сарын 15, Баасан гариг

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах хүн
---------	---------------	--------------

09 ⁰⁰ -09 ³⁰	Бүртгэл	Зохион байгуулагчид
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЭЛ		
09 ³⁰ -12 ³⁰	Чиглүүлэгч: Б.Сансармаа, ЭЭТТА-ны ахлах мэргэжилтэн	
09 ³⁰ -10 ⁰⁰	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөгжил ба бүртгэх асуудалд	<i>Б.Энхжаргал, Эрүүл мэндийн сайдын зөвлөх, Техникийн ухааны доктор, профессор</i>
09 ³⁰ -10 ⁰⁰	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан програм хангамжийн ерөнхий танилцуулга	<i>М.Тогтуунбаяр, Програмын зөвлөх</i>
10 ⁰⁰ -10 ³⁰	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журмын танилцуулга	<i>Б.Сансармаа, ЭМХТ-ийн ЭЭТТА-ны ахлах мэргэжилтэн</i>
10 ³⁰ -11 ⁰⁰	Цайны завсарлага	
11 ⁰⁰ -11 ³⁰	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ерөнхий нэршлийн танилцуулга	<i>Б.Батцоож, ЭМХТ-ийн ЭЭТТА-ны мэргэжилтэн</i>
11 ³⁰ -12 ³⁰	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан програм хангамжийн ашиглалт	<i>Б.Тогтохдорж, Програмист</i>
12 ³⁰ -13 ³⁰	Үдийн завсарлага	
ХОЁРДУГААР ХЭСЭГ. ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ДАДЛАГА СУРГАЛТ		
13 ³⁰ -17 ³⁰	Чиглүүлэгч: Б.Батцоож, ЭЭТТА-ны мэргэжилтэн	
13 ³⁰ -15 ⁰⁰	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг ашиглах, мэдээлэл оруулж турших	<i>Програмын зөвлөхийн баг (Бүлгээр ажиллах)</i>
15 ⁰⁰ -15 ³⁰	Цайны завсарлага	
15 ³⁰ -17 ⁰⁰	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг ашиглан тайлан гаргах	<i>Програмын зөвлөхийн баг (Бүлгээр ажиллах)</i>
Хаалтын үйл ажиллагаа		
17 ⁰⁰ -17 ²⁰	Дурсгалын зураг авахуулах, гэрчилгээ гардуулах	Зохион байгуулагчид
17 ²⁰ -17 ³⁰	Хаалт	Зохион байгуулагчид

Хавсралт 2. Уулзалт, семинарын батлагдсан удирдамж



Зорилт:

- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний өнөөгийн байдлын үнэлгээний тайлан танилцуулах;
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, мэдээний сангийн програм хангамжийг танилцуулах, нээлт хийх, турших;
- Эх, нярайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний чиглэлээр сургалт хийх;

Үр дүн: Эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний өнөөгийн байдлын үнэлгээний тайланг хэлэлцүүлэн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, мэдээний сангийн програм хангамжтай танилцан цаашид авах арга хэмжээг тодорхойлно.

Зохион байгуулагч:

- ЭМЯ – Эм, үйлдвэрлэл, технологийн газар
- ЭМХТ – Эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба

Санхүүжүүлэгч байгууллага: НҮБ-ын Хүн амын сан

Хаана: Эрүүл мэндийн яам, Хурлын Б танхим


Хэзээ: 2018 оны 06-р сарын 14-ноос 15-ны өдрүүдэд


Хамрах хүрээ:


- Эрүүл мэндийн яамны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд,
- Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллагууд,
- Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хариуцсан инженер техникч нийт 100 мэргэжилтэн хамрагдана.

Хүрэх үр дүн:

- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт засвар үйлчилгээний өнөөгийн байдлын үнэлгээний үр дүнд үндэслэн цаашид авах арга хэмжээг тодорхойлогдсон байна.
 - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл нэршлийн үндсэн ойлголттой болж, мэдээллийн сангийн програм хангамж туршигдсан байна.
 - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний журмын төсөл хэлэлцэгдэж, санал авсан байна.
- Эх, нярайн чиглэлийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний талаар оролцогчдын мэдлэг чадвар сайжирсан байна.

Хянасан:  Ш.Энхзаяа /ЭЗТТА-ны дарга/

Боловсруулсан:  Б.Сансармаа /ЭЗТТА-ны ахлах мэргэжилтэн/

 Б.Батцоож /ЭЗТТА-ны мэргэжилтэн/

Хавсралт 4. Уулзалт, семинарын зураг ба гэрчилгээ

